

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2013 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

**Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа  
эрхлэх зөвшөөрөл олгох тухай**

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

3. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.


4. Тушаалын үнэт цаасны бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2013 оны 09 сарын 09 өдрийн  
6/ тоот тушаалын хоёрдугаар хавсралт




ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

2013.09.18

Улаанбаатар хот

д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Зориг халиун ХХК	Бэлх	Сүхбаатар дүүрэг, 18-р хороо, Бэлхийн 35-5-51а
2	Вай-Эм-Ти ХХК	Өргөө	Баянзүрх дүүрэг, 13-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 113

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2013 оны 09 сарын 18 өдрийн  
6/ тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН  
НЭГЖИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

2013.09.18

Улаанбаатар хот

д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Эхэн трейд ХХК	Соёмбо	Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бага тойруу 26 в